

Сурагчийн нэр:


Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Усны эргэлтийг загварчлан тайлбарлах

1.Зурагт усны эргэлтийн загвар өгөгдсөн байна.

Даалгавар



а. Диаграммаар үзүүлсэн **A, B, C, D** процессын нэрийг зөв холбоно уу.

- | | |
|----------|-------------|
| A | Конденсац |
| B | Ууршилт |
| C | Хур тунадас |
| D | Транспирац |

b. Борооны усны зарим хэсэг хуурай газрын чулуулагт нэвчиж газрын хэвлийгээр шилждэг. Зурагт ямар үсгээр тэмдэглэсэн байна вэ?

.....


c. Усны эргэлтэд ургамлын үндэс усыг шингээж, навчаараа дамжуулан усны уур хэлбэрээр ялгаруулах үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ?

.....

d. Усанд сэлэгчид усан сангаас гараад наранд суухад нойтон арьс нь хурдан хатдаг. Энд усны ямар үзэгдэл явагдаж байгаа вэ?

.....

e. Доорх схем нь байгаль дах усны эргэлтийн үйл явцыг харуулж байна. Хоосон хэсгийг гүйцээж бичнэ үү.



Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:


Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Нүүрстөрөгчийн эргэлтийг загварчлан тайлбарлах

Даалгавар 1. Зурагт нүүрстөрөгчийн эргэлтийн загвар өгөгдсөн байна.



а. Нүүрстөрөгчийг эргэлтийг ажиглаад P, Q, R ба S -ийн нэр болон тус бүрт тохирох жишээг бичээрэй.

Үсэг	Циклийн хэсгийн нэр	Хэсэг тус бүрд олддог нүүрстөрөгчид нэгдэл
P	Атмосфер / агаар	
Q		Цардуул, целлюлоз
R		Гликоген, уураг, нуклейн хүчил
S		Нүүрс ус, уураг, өөх тос
T	Чулуужсан түлш, байгалийн хий	метан

б. Фотосинтез нь нүүрстөрөгчийн эргэлтийн маш чухал үйл явцын нэг юм. Фотосинтезийн үед Q нь P-ээс ямар нэгдлийг авч нүүрстөрөгч болгон хувиргадаг болохыг тайлбарлаарай.

.....

.....

с. Агаарын найрлага дахь нүүрсхүчлийн хийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү.

1.
2.
3.

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:


Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Популяцын тоо толгой, өсөлт болон бууралтад нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодруулах

Даалгавар

2. Туулай бол өвсөн тэжээлтэн юм. Графикт туулайн популяцын тоо толгойн өсөлт болон бууралтыг харуулсан.



Туулайны популяц өсөх болон буурахад нөлөөлдөг 2 хүчин зүйлийг тодорхойлж бичээрэй.

Өсөхөд:

1

2

Буурахад:

1

2

3. Төрөлт болон иммиграци явагдах бүрд популяцын хэмжээ өсөх бөгөөд үхэл хорогдол болон эмиграци явагдах бүрд хэмжээ нь буурна.

Популяцын хэмжээний өөрчлөлтийг тодорхойлох тэгшитгэлийг нөхөж бичнэ үү.

Популяцийн хэмжээний өөрчлөлт

=

+

-

-

4. Экосистемийн даацыг хэтрүүлэн популяц өсөхөд тухайн популяцад хамгийн их тохиолддог зүйл юу вэ?

.....



Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Популяцын тоо толгойд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох

Даалгавар

1. Популяцын тоо толгойн хэлбэлзэл нь олон хүчин зүйлээс хамаарна. Аль тохиолдолд популяцын тоо толгой өсөх ба буурахыг хүснэгтэд тэмдэглэнэ үү.

Популяцын тоо толгойд нөлөөлөх хүчин зүйлс	Тоо толгой өснө	Тоо толгой буурна
Популяцын идэш тэжээл элбэг байх		
Идэш тэжээлийн хэлхээний нэг түвшний хэрэглэгч амьтдын тоо өсөх		
Өрсөлдөгч амьтдын тоо, махчид, шимэгчдийн тоо цөөрөх		
Цаг агаарын гэнэтийн гамшгаас бие гүйцээгүй амьд биеүүд олноороо эрсдэх		

2. Популяцын тоо толгойд нөлөөлөгч хүчин зүйлсээс цаг агаарын үзэгдэл нь хүйтэн цуст амьтдад илүү их нөлөөлдөг. Яагаад?

.....

.....

3. Популяцын нягтшил өсөхийн хэрээр олонх хүчин зүйлүүдийн үйлчлэлүүд нэлээд ширүүн болно. Ийм хүчин зүйлүүдийг нягтшилаас хамаардаг хүчин зүйлс гэнэ. Үүнд ямар хүчин зүйлс хамаарах вэ?

.....

.....

4. Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээн нөхөж, популяцын талаарх мэдлэгээ үнэлээрэй.

популяцын нягтшил, стресс, гомеостаз

Нэгж талбай юмуу эсвэл тодорхой хэмжээний эзлэхүүн дэх бодгаль болон массын тоон үзүүлэлтийг гэнэ.

Аливаа амьд системд, түүний дотор популяцид хувийн, өөрийгөө зохицуулах механизмын тусламжтайгаар, дотоод тогтвортой байдлаа хадгалах хандлага байдаг. Үүнийг гэнэ.

Популяцид ямар нэгэн хүчтэй цочрол үйлчилбэл популяц нь түүнд хариу үйлдэл үзүүлэхийг гэнэ.

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Хүний үйл ажиллагаа амьдрах орчны бохирдолд нөлөөлөх, тодорхой нэг экосистемийг хамгаалах ажлыг төлөвлөх

Даалгавар

5. Монгол орны нутаг дэвсгэрийн 8 орчим хувь нь ойгоор бүрхэгдсэн ба ой нь ихэвчлэн нутгийн хойд хэсгээр тархан ургана. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан ойн түймэр, ойн хөнөөлт шавжийн тоо хэмжээ ихэсч ойн тархалт, нөөцөд ихээхэн хохирол учруулж байна.

Жил	Түймэрт өртсөн ойн талбай мян/га
2015	184
2016	141
2017	220
2018	77
2019	121
2020	139
https://1212.mn статистикийн мэдээллийн нэгдсэн сан	

Хүснэгтэд 2015 – 2020 оны хооронд жил бүр ойн түймэрт өртсөн талбайн хэмжээг үзүүлэв.

а. 2015 - 2020 он хүртэлх хугацаанд түймэрт өртсөн ойн талбайн жилийн дунджийг тооцоолоорой.

..... мян/га

6. Ой модыг устгах нь агаар мандалд нүүрсхүчлийн хийн агууламж нэмэгдэхэд хүргэдэг. Ой модыг устгаснаас үүсэх бусад сөрөг нөлөөнөөс 2-ыг бичнэ үү.

1

2

7. Байгаль орчин болон хүний амьдрал ахуйд ургамлын үзүүлэх ач холбогдлоос тус бүр 3-г бичнэ үү.

Байгальд үзүүлэх ач холбогдол:

1.....

2.....

3.....

Хүний амьдрал ахуйд үзүүлэх ач холбогдол:

1.....

2.....

3.....

8. Ой мод устгах болсон үндсэн шалтгаануудаас 3-ыг бичнэ үү.

1.....

2.....

3.....

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:


Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Бүлгийн үнэлгээний даалгавар

1. Усны эргэлтийн диаграммыг доор үзүүлэв. А –аас D хүртэл болж буй үйл явцыг үзүүлээ.




Аль сум нь транспирацын үйл явцыг харуулсан байна вэ?

- A. D B. C C. B D. A

2. Зурагт нүүрстөрөгчийн эргэлтийн диаграммыг харуулжээ.

Аль тоо нь ялгаруулалтыг харуулж байна вэ?

- A 1 ба 2 B. 1 ба 4 C. 2 ба 3 D.
1 ба 3



3. Нэгдмэл нэг газар нутагт хамт оршин амьдарч, бие биедээ байнга нөлөөлдөг, хүрээлэн буй орчны нөхцөлийн өөрчлөлтийг тэсвэрлэн, тоо толгойн байдлаа удаан хугацаанд тогтмол барих чадвар бүхий нэг зүйлийн бодгалиудыг гэнэ.

- A. Бүлгэмдэл B. Зүйл C. Популяц D. Хабитат

4. Эх газраас ууршсан ус хур тунадас болж эх газартаа буцаж буухыг ямар эргэлт гэдэг вэ?

- A. Байгаль дахь усны эргэлт B. Усны гадаад эргэлт
C. Усны дотоод эргэлт D. Усны нийт эргэлт

5. Популяцын хамгийн бага нэгжийг юу гэдэг вэ?

- A. Эгэл популяц B. Экологийн популяц C. Газар зүйн популяц

6. Аль нь конденсацыг зөв дүрсэлсэн байна вэ?

- A. Агаар мандал дахь усны уур температурын нөлөөгөөр хатуу төлөвт шилжих
B. Агаар мандал дахь усны уур хийн төлвөөс шингэн төлөвт шилжих
C. Навчийн амсрын эсээр ус уурших

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Бүлгийн үнэлгээний даалгавар

7. Популяцын тоо толгой, нягтшил ямар тохиолдолд тогтмол байх вэ?

- A. Үхэл хорогдол бага байх үед
- B. Төрөлт өндөр байх үед
- C. Төрөлт нь үхэл хорогдлоос давуу байх үед
- D. Төрөлт ба үхлийн эрчим тэнцүү байх үед

8. Ой модыг устгаснаар аль процесс явагдах вэ?

- a. Ойн амьтдын төрөл зүйл устах
- b. Үерийн усны эрсдэл нэмэгдэх
- c. Фотосинтезийн бууралт
- d. Хөрсний элэгдэлт

9. Химийн бохирдлыг үүсгэгч бодисуудыг эх үүсвэртэй нь зөв тохируулна уу.

- 1. Мөнгөн ус a. Бензинээр ажилладаг дотоод шаталтын хөдөлгүүр бүхий машинууд
- 2. Хар тугалга b. Ашигт малтмал, алтны олборлолт
- 3. Кадми c. Арьс ширний үйлдвэрт ашигладаг идээлэгч бодис
- 4. Хром d. Боловсруулаагүй нүүрсийг нам температурт дутуу шатаах

10. Усны эргэлтийг зөв тохируулна уу.

1. Конденсац	a. ургамлын үндэс усыг шингээж, навчаараа дамжуулан усны уур хэлбэрээр ялгаруулах үйл явц
2. Транспирац	b. агаар дахь усны уурыг шингэн ус болгон хувиргах үйл явц
3. Усны эргэлт	c. нарны хурц тусгал нь далай тэнгисийн усыг халааж усны молекулыг хөдөлгөөнд оруулах үйл явц
4. Ууршилт	d. гол, мөрөн, нуур, далай тэнгисийн гадаргаас ууршсан усны уур агаарт дэгддэг, мөн газрын гүний усыг ургамал үндсээрээ сорон авч навчаараа дамжуулан их хэмжээний усыг ууршуулдаг, дараа нь цас бороо мэтийн хур тунадас болж эргээд усны болон хуурай газрын гадаргууд буух

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Бүлгийн үнэлгээний даалгавар

11. Хүний үйл ажиллагааны үр дүнд байгаль орчин их хэмжээгээр бохирддог.

а. Доорх хүснэгтэд хүрээлэн буй орчныг бохирдуулж буй жишээ тус бүр 2-ыг бичиж гүйцээгээрэй. Хэсэг тус бүрд өөр өөр бохирдуулагчийг нэрлэхийг анхаараарай. [3]

Хүрээлэн буй орчин	Бохирдуулагч
Агаар	1.
	2.
Газар	1.
	2.
Ус	1.
	2.

б. Гербицидийг тариаланчид хогийн ургамалтай тэмцэхэд ашигладаг. Үүний улмаас байгаль орчинд учирч болох хоёр хохирлыг нэрлээд, тайлбарлаж бичээрэй. [2]

.....

.....

.....

.....

Амьд бие хоорондын болон орчны харилцан холбоо

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээний зураглал.

Түвшин 10 (III)			
Популяцын тоо толгойд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох		Хүний үйл ажиллагаа амьдрах орчны бохирдолд нөлөөлөх, тодорхой нэг экосистемийг хамгаалах ажлыг төлөвлөх	
Эхэлсэн		Эхэлсэн	
Дууссан		Дууссан	
Өөрийн үнэлгээ		Өөрийн үнэлгээ	
Багшийн үнэлгээ		Багшийн үнэлгээ	
Түвшин 10 (II)			
Нүүрстөрөгчийн эргэлтийг загварчлан тайлбарлах		Популяцын тоо толгой, өсөлт болон бууралтад нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодруулах	
Эхэлсэн		Эхэлсэн	
Дууссан		Дууссан	
Өөрийн үнэлгээ		Өөрийн үнэлгээ	
Багшийн үнэлгээ		Багшийн үнэлгээ	
X АНГИ			
Түвшин 10 (I)			
Усны эргэлтийг загварчлан тайлбарлах			
Эхэлсэн			
Дууссан			
Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ			

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:


Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Экосистем дэх идэш тэжээлийн сүлжээний гишүүдийн үүрэг, хэрхэн нөлөөлөхийг тайлбарлах

Даалгавар

Доорх зурагт цөлийн экосистемийн идэш тэжээлийн сүлжээний загварыг үзүүлсэн байна.



1. Энэ идэш тэжээлийн сүлжээн дэх гуравдагч хэрэглэгчдийн нэрийг бичнэ үү.

1.

2.

2. Дээрх сүлжээнээс 4 өөр организмтай, шонхор шувуугаар төгсдөг идэш тэжээлийн хэлхээг сонгож, схемд нөхөж бичнэ үү.



3. Идэш тэжээлийн сүлжээн дэх царцааны тоо гэнэт буурсан бол хилэнцэт хорхойн тоо толгой болон цөлийн ургамлын популяцид ямар нөлөө үзүүлэхийг тайлбарлаарай.

Хилэнцэт хорхой.....

Цөлийн ургамал

4. Экосистем дэх энергийн шилжилтийг яагаад энергийн эргэлт биш, энергийн урсгал гэж ярьдаг вэ?

.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Орон нутгийн доройтолд орсон амьдрах орчныг нөхөн сэргээхийн ач холбогдлыг хэлэлцэж, тайлбарлах

Даалгавар

5. Говь цөлийн экосистемийн зургийг ажиглаад дасгалуудыг гүйцэтгэнэ үү.



а. Говийн экосистемын хоол тэжээлийн хэлхээний анхдагч болон 2-догч хэрэглэгчээс 3 –ыг нэрлэж бичнэ үү.

Анхдагч хэрэглэгч:

Хоёрдогч хэрэглэгч:

б. Говийн экосистем өөрчлөгдөхөд нөлөөлсөн 2 хүчин зүйлсийг нэрлээд, хэрхэн нөлөөлснийг дүрслэн бичээрэй.

.....

г. Экосистем хувьсаж өөрчлөгдсөнөөр амьд бие болон амьдрах орчинд ямар ямар сөрөг үр дагавар гарахыг тайлбарлаарай.

.....

д. Цөлжилт болон хөрсний элэгдлийг бууруулж, экосистемийг нөхөн сэргээх ямар боломж нөхцлүүд байна вэ? Чи ямар хувь нэмэр оруулж чадах вэ?

.....

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Орон нутгийн жишээнд үндэслэн доройтолд орсон амьдрах орчинг нөхөн сэргээхийн ач холбогдлыг хэлэлцэж, тайлбарлах

Даалгавар

1. Усны тухай Монгол улсын хуулийн дагуу усны тооллогыг улсын хэмжээнд 4 жил тутамд холбогдох мэргэжлийн байгууллага явуулж, үр дүнг улсын мэдээллийн санд нэгтгэдэг. Тооллого явуулах үед гол горхи, булаг шанд, рашаан, нуур тойром нь усгүй болсон тохиолдолд ширгэсэнд тооцдог байна.

Жил	Хатаж ширгэсэн гол горхи, булаг шанд, нуур, рашааны тоо / ширхэг/	Сэргэсэн гол горхи, булаг шанд, нуур, рашааны тоо / ширхэг/
2007	3747	429
2011	3613	265
2014	2738	450
2016	2214	490
2017	3598	450
2018	2914	373

<https://1212.mn>
статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Хүснэгтэд 2007 – 2018 оны хооронд явуулсан усны тооллогын дүн мэдээг үзүүлсэн.

а. 2007- 2018 он хүртэлх хугацаанд жилд дунджаар хатаж ширгэсэн гол горхи, булаг шанд, нуур, рашааны тоог тооцоолоорой.

..... ширхэг

б. Гол горхи, булаг шанд, нуур ширгэснээс гарах үр дагавраас 2-ыг бичнэ үү.

1.....

2.....

с. Дээрх хүснэгтэд үзүүлсэн мэдээллийг ашиглан тухайн тооллого хийсэн онуудад хичнээн гол горхи, булаг шанд, нуур рашаан **нөхөн сэргэхгүйгээр** ширгэсэн тоон үзүүлэлтийг гаргаж, үр дүнгээр баганан график дэвтэртээ байгуулаарай.

Жил	Нөхөн сэргэхгүй ширгэсэн гол горхи, булаг шанд, нуур, рашааны тоо / ширхэг/
2007	
2011	
2014	
2016	
2017	
2018	

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Бүлгийн үнэлгээний даалгавар

1. Улаан буудайн талбайн ургамлыг сүйтгэж, устгадаг өвчин тухайн экосистемийг хамарсан бол улаан буудайгаар хооллодог шувуудын популяцид ямар өөрчлөлт гарах вэ?
- Шувууны тоо толгойд өөрчлөлт гарахгүй
 - Шувууны тоо толгой нэмэгдэх болно
 - Шувууны тоо толгой буурах болно.



2. Популяцын тоо толгойн хэлбэлзлийг гэнэ.
- Популяцын нягтшил
 - Популяцын цэвэр өсөлт
 - Популяцын үхэл хорогдол
 - Популяцын хөдлөл зүй



3. Тухайн нутаг дэвсгэр дэх биотик болон абиотик хүчин зүйлс, тэдгээрийн хоорондын харилцан үйлчлэлээс бүрдсэн системийг юу гэж нэрлэдэг вэ?
- Ниш
 - Экосистем
 - Дасан зохицох
 - Идэш тэжээлийн хэлхээ

4. Дараах зүйлсийн аль нь популяцын нягтшилаас хамааралгүй хязгаарлагч хүчин зүйл вэ?
- Нөөцийн төлөөх өрсөлдөөн
 - Махчин амьтан
 - Өвчин
 - Байгалийн гамшиг

5. Ихэнх идэш тэжээлийн сүлжээний эрчим хүчний гол эх үүсвэр нь юу байдаг вэ?
- Нүүрстөрөгчийн давхар исэл
 - Глюкоз
 - Хүчилтөрөгч
 - Нарны гэрэл

6. Бүлээр амьдардаг амьтан аль нь вэ?

A. Цагаан зээр B. Үхэр огодой C. Зурам D. Тарвага

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Бүлгийн үнэлгээний даалгавар

7. Зурагт үзүүлсэн идэш тэжээлийн тогтвортой сүлжээнд туулайн тоо толгойг гэнэт хоёр дахин нэмэгдүүлбэл ямар өөрчлөлт гарах вэ?



- A. Ургамал болон шонхор шувууны тоо толгой буурах, могойн тоо толгой өсөх
- B. Бусад гурван зүйлийн популяцын тоо толгой нэмэгдэх
- C. Бусад гурван зүйлийн популяцын тоо толгой буурах
- D. Ургамлын хэмжээ буурах, могой болон шонхор шувууны тоо толгой нэмэгдэх

8. Хээрийн экосистемд хамт тохиолддог дараах зүйлүүдээс аль нь хэрэглэгч вэ?

- A. Хялгана B. Таана C. Үлийн цагаан оготно D. Агь

9. Гол дагуу өөр өөр газраас 4 усны дээж цуглуулсан. Дээж тус бүрт нийт организмын дундаж тоо болон өөр өөр зүйлийн организмын тоог тоолсон. Хүснэгтэд үр дүнг харуулав. Аль усны дээж хамгийн их бохирдолтой байна вэ?

	Нийт организмын дундаж тоо	Зүйлийн тоо
A	650	5
B	280	30
C	400	17
D	420	43

10. Идэш тэжээлийн хэлхээг зөв илэрхийлсэн хувилбарыг сонгоно уу.

- A. Өвс – далайн хав – загас – шувуу
- B. Өвс – минж – чийгийн улаан – цахлай
- C. Өвс – зээр – чоно – бичил биетэн
- D. Өвс – хонь – бичил биетэн- чоно

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:


Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг



Бүлгийн үнэлгээний даалгавар

11. Зурагт идэш тэжээлийн сүлжээг харуулсан байна.



a. Идэш тэжээлийн сүлжээний бүтээгчийг нэрлээрэй. [1]

.....

b. Зураг дээр хоёрдогч хэрэглэгчийг дугуйлна уу. [1]

c. Энэхүү идэш тэжээлийн сүлжээнд тэжээлийн хэдэн түвшин байна вэ? [1]

.....

d. Дээрх сүлжээг ашиглан өгөгдсөн идэш тэжээлийн хэлхээг гүйцээгээрэй. [2]



Сурагчийн нэр:

Эхэлсэн:онсар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээний зураглал.

Түвшин 11(III)		XI анги			
Орон нутгийн доройтолд орсон амьдрах орчныг нөхөн сэргээхийн ач холбогдлыг хэлэлцэж, тайлбарлах					
Эхэлсэн					
Дууссан					
Өөрийн үнэлгээ					
Багшийн үнэлгээ					
Түвшин 11 (II)					
Экосистем дэх идэш тэжээлийн сүлжээний гишүүдийн үүрэг, хэрхэн нөлөөлөхийг тайлбарлах		Орон нутгийн доройтолд орсон амьдрах орчныг нөхөн сэргээхийн ач холбогдлыг хэлэлцэж, тайлбарлах			
Эхэлсэн		Эхэлсэн			
Дууссан		Дууссан			
Өөрийн үнэлгээ		Өөрийн үнэлгээ			
Багшийн үнэлгээ		Багшийн үнэлгээ			

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ: